

**ЭРҮҮЛ МЭНДИЙН АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН  
/ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/ ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААР  
НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2014 оны 10 дугаар  
сарын 08-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2014 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрүүл мэндийн албан журмын даатгалын тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг тус Байнгын хороо 2014 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Иргэн бүрийг эрүүл мэндийн албан журмын даатгалд бүрэн хамруулж, даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, даатгалын сангийн менежментийг сайжруулах, эрүүл мэндийн даатгалын тогтолцоог төгөлдөржүүлэх зорилгоор хуулийн төслийг боловсруулжээ.

Мөн хуулийн төсөлд даатгуулагчийн эрх үүргийг тодорхойлж, даатгалаас санхүүжүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, хамрах хүрээг шинэчлэх, эрүүл мэндийн даатгалын сангийн төлөвлөлт, зарцуулалтыг оновчтой болгох, эрүүл мэндийн даатгалаас үйлчилгээ үзүүлэгчид олгох санхүүжилтийг тусламж, үйлчилгээний чанартай уялдуулах, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох, даатгуулагчийн цахим үнэмлэхийг нэвтрүүлж, төрөөс шимтгэлийг хариуцан төлөх даатгуулагчийн шимтгэлийн хэмжээг нэмэгдүүлэх болон эрүүл мэндийн даатгалын багцыг тусламж, үйлчилгээний нэр, төрөл хэлбэрээр нь тодорхойлж, даатгуулагчийн төлөх төлбөрийг бууруулах зэрэг зохицуулалтуудыг тусгасан байна.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулж, тусламж үйлчилгээг чирэгдэлгүй, хүртээмжтэй болгох хөшүүргийг тодорхой болгох, Улсын Их Хурлын гишүүн А.Тлейхан урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд бүх нийтээр нь хамруулах, түүнийг хэрэгжүүлэх арга замыг тодорхой зааж, даатгалаас санхүүжүүлэхээр төсөлд тусгах, Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан төрөөс хариуцах шимтгэлийн хэмжээг нэмэгдүүлэхэд төсөвт ирэх нэмэлт ачааллыг тооцоолох нь зүйтэй гэсэн саналуудыг тус тус гаргалаа.

Хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг тус Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтэй дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эрүүл мэндийн албан журмын даатгалын тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ төслийг хэлэлцэх эсэх талаар Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Д.БАТЦОГТ

